



I-III/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 14



ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 4.2 ХУВИАР БУУРЛАА

Даатгалын хураамжийн орлого 2021 оны эхний улиралд 39.0 тэрбум төгрөгт хүрч, даатгалын нөхөн төлбөрт 12.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс даатгалын хураамжийн орлого 1.7 (4.2%) тэрбум төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 3.3 (21.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Хүснэгт 1. Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгуулагчид

	2018	2019	2020	2021*	2021* I-III
	I-III	I-III	I-III	I-III	2020 I-III
	сая төгрөг				хувь
Хураамжийн орлого	34 952.4	38 309.9	40 675.7	38 956.5	95.8
Нөхөн төлбөр	11 339.3	12 549.3	15 643.5	12 316.9	78.7
Даатгуулагчид, мянган нэгж	332.9	361.2	328.7	377.3	114.8
Хувь хүн, мянган хүн	291.9	309.7	274.8	276.8	100.7

Зураг 1. Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэрбум төгрөгөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын эцэст



Даатгалын хураамжийн орлого 2021 эхний улиралд өмнөх оны мөн үеэс 1.7 (4.2%) тэрбум төгрөгөөр буурахад хөрөнгийн даатгалын хураамжийн орлого 1.3 (17.8%) тэрбум төгрөгөөр, барилга угсралтын даатгалын хураамжийн орлого 5.8 (88.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Даатгалын нөхөн төлбөр 2021 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 3.3 (21.3%) буурахад жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр 1.1 (21.3%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр 0.7 (41.9%) тэрбум төгрөгөөр, зээлийн даатгалын нөхөн төлбөр 0.5 (55.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Даатгалын хураамжийн 2021 оны эхний улирлын нийт орлогын 23.7 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 17.4 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 15.3 хувийг хөрөнгийн даатгал, гэнэтийн осолын даатгал 14.0 хувийг эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн 2021 оны эхний улирлын нийт төлбөрийн 33.8 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 32.0 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, гэнэтийн осолын даатгал 17.3 хувийг эзэлж байна.

Даатгуулагчид 2021 оны эхний улиралд 377.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 48.6 (14.8%) мянгаар өссөн байна. Даатгуулагчдын 73.4 хувь нь иргэн, 26.6 хувь нь хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж, байгууллага байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.

Эх үүсвэр: Санхүүгийн Зохицуулах Хороо

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 6 дугаар сарын 15

Хавсралт:

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч
А.Мөнхцэцэг
Утас: (976-51)-261565

Эдийн засгийн статистикийн
газрын дарга
Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414